- *Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай*
- *Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолоор “төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай”*

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөө багатай байна.

Сумын нэгтгэсэн санхүүгийн тайланд мөрдөх тусгайлан баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг байхгүй бөгөөд Сангийн яамнаас гаргасан бодлого шийдвэрүүдийг хэрэгжүүлэн и-баланс цахим программ хангамж ашиглан холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцүүлэн, үйл ажиллагааны онцлогт тохируулан ашиглаж байна.

Чандмань сумын Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд аймгийн Засаг даргын дэргэдэх санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас 2018-2020 оны санхүүгийн үйл ажиллагаанд 2021 оны 09 дугаар сард дотоод хяналт хэрэгжүүлсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Чандмань сумын ТТЗ-ын 2021 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлаар сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт орлогын 4,292.2 сая төгрөгөөс 1.5 хувиар тооцон 64.4 сая төгрөгөөр материаллаг байдлыг тооцон, санхүүгийн тайлангийн түвшинд гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 48.3 сая төгрөгөөр тогтоолоо.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Чандмань сумын ТТЗ-ын 2021 оны нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,311.5 сая төгрөгөөр буюу 18 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр, цэвэр өмчийн данснууд байна.

Хүснэгт №1. Санхүүгийн байдлын тайлан

/сая. төгрөг/

Тайлангийн үзүүлэлтүүд	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт	
Мөнгөн хөрөнгө	66.0	79.0	-13.00	120%
Авлага	582.3	592.2	-9.90	102%
Бараа материал	140.1	193.5	-53.40	138%
Үндсэн хөрөнгө	6,316.7	7,551.9	-1,235.20	120%
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	7,105.1	8,416.6	-1,311.50	118%
Богино хугацаат өр төлбөр	16.6	47.8	-31.20	288%
Урт хугацаат өр төлбөр	15.0	15.0	0.00	100%
Цэвэр хөрөнгө, өмч	7,073.5	8,353.8	-1,280.30	118%
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	7,105.1	8,416.6	83,525.21	118%

Эх сурвалж: Чандмань сумын ТТЗ-ын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 66.0 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 79.0 сая төгрөг болж 13.0 сая төгрөгөөр буюу 20 хувиар өссөн байна. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд байгаа 79.0 сая төгрөг нь Төрийн сангийн харилцах дансанд байршиж байна.

3.5.2 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 582.3 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 592.2 сая төгрөг болж 9.9 сая төгрөг буюу 1.7 хувиар өссөн байна.

Хүснэгт 2: Авлагын үлдэгдэл

сая. Төгрөг

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	8.20	16.2	8.0
Төлбөртэй үйлчилгээний авлага	0.30	63.9	63.6
Байгууллагаас авах авлага	101.10	105.1	4.0
Хувь хүмүүсээс авах авлага	31.30	10.8	(20.5)
Зээлийн хүүгийн авлага	395.2	382.2	(13.0)
Татвар, НДШ /ОНӨААТҮГ/	6.3	6.3	-
Татаас санхүүжилтийн авлага	-	2.5	2.5
Дүн	542.4	587.0	44.6

Урьдчилж гарсан зардал		-	-
Тусгай зориулалтын сан	-	-	-
Үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа	39.4	4.2	(35.2)
Цалингийн урьдчилгаа	0.5	1.0	0.5
Дүн	39.9	5.2	(34.7)
АВЛАГЫН НИЙТ ДҮН	582.3	592.2	9.9

Эх сурвалж: Чандмань сумын ТТЗ-ын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлагын үлдэгдэлд 115.6 сая төгрөгийн насжилт өндөртэй байгаа авлагын дийлэнхийг сум хөгжүүлэх сангийн зээл 71.5, Чандмань хөгжүүлэх сангийн зээл 44.1 сая төгрөгийн зээл, зээлийн хүүгийн авлага эзэлж байгаа бөгөөд оны эхэнд 321.2 мянган төгрөгийн зээлийн авлагын үлдэгдэлтэй байсан ба тайланд 172.7 сая төгрөгийн төлөгдөж 162.2 сая төгрөгийн зээл олгогдож, 39.7 сая төгрөгийн зээл, зээлийн хүү эргэн төлөгдөж, оны эцэст 310.6 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Чандмань БИТ ОНӨҮГ анх байгуулагдахад 15.0 сая төгрөгийн зээлийг сум хөгжүүлсэн сангаас олгосон бөгөөд уг ОНӨҮГ нь үйл ажиллагаа нь алдагдаж татан буугдсантай холбоотой төлөгдөх боломжгүй болсон байна.

ОНХС-гийн авлагад бүртгэлтэй малжуулах төсөл хөтөлбөрийн авлагын эхний үлдэгдэл 74.0 сая төгрөгөөс тайлант онд 2.4 сая төгрөгийн авлагыг барагдуулж 71.6 сая төгрөгийн үлдэгдэл байгаагаас 54.2 сая төгрөгийн авлага нь насжилт өндөртэй хугацаа хэтэрсэн үлдэгдэлтэй байна.

3.5.3 Бараа материал

Бараа материалын дансны үлдэгдэл 193.5 сая төгрөг болж 53.4 сая төгрөгөөр өссөн нь 83.5 сая төгрөгөөр эм боох материал, аж ахуйн материалыг үнэ төлбөргүйгээр хүлээн авсантай холбоотой нэмэгдсэн байна.

Тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 279.3 сая төгрөгийн бараа материал бэлтгэж, үнэ төлбөргүйгээр 83.5 сая төгрөгөөр нийт 362.8 сая төгрөгөөр нэмэгдэж, 309.4 сая төгрөгийн материалыг зарцуулжээ.

3.5.4 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл оны эхэнд 8,368.4 сая төгрөг байсан бол оны эцэст 9,788.7 сая төгрөг болж 1,420.3 сая төгрөгөөр өссөн нь 43.7 сая төгрөгийн хөрөнгийг худалдан авсан, 1,539.6 сая төгрөгөөр хандив, үнэ төлбөргүйгээр нэмэгдсэн нь тайлант онд Нутгийн удирдлагын ордон, Халуун усны барилга шинээр баригдаж ашиглалтад орсонтой холбоотой байна.

Тайлант онд үндсэн хөрөнгө 1,539.6 сая төгрөгөөр нэмэгдсэн нь төсвийн хөрөнгөөр үнэ төлбөргүй, хандиваар нэмэгдэж, 162.9 сая төгрөгийн хөрөнгө акталж хасагдсан байна.

3.5.6 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 31.7 сая, оны эцсийн үлдэгдэл 62.8 сая төгрөг болж 31.1 сая төгрөгөөр өссөн байна. Богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэлд 47.8 сая төгрөгийн өр, байгаа нь дараа тайлангийн хугацаанд бүрэн барагдах боломжтой байна.

Богино хугацаат өр төлбөрийн 4.1 сая төгрөг нь ажилчидтай холбоотой өглөг, 29.4 сая төгрөг нь бараа үйлчилгээний өглөг, 1.0 сая төгрөг нь татаас санхүүжилтийн өглөг, 4.0 сая төгрөг нь байгууллагад өгөх өглөг өр төлбөр байна.

Урт хугацаат өр төлбөрт 15.0 сая, богино хугацаат өр төлбөр буюу Татварын өглөг 9.3 сая төгрөгийн төгрөгийн үлдэгдэл нийт 24.3 сая төгрөгийн өр төлбөр нь Чандмань БИТ ОНӨҮГ-тай холбоотой үүссэн барагдах боломжгүй байна.

3.5.7 Цэвэр хөрөнгө, өмч

Засгийн газрын оролцоо дансны оны эхний үлдэгдэл 8,353.8 сая төгрөг байсан оны эцэст 6,434.3 сая төгрөг тайлант онд 674.2 сая төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн 426.5 сая төгрөгийн ашигтай, өмнөх үеийн үр дүн рүү 247.8 сая төгрөгөөр залруулсантай холбоотой байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 2,815.0 сая төгрөгөөр, нийт зарлагыг 2,815.0 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Чандмань сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны нэгтгэсэн төсвийг аймгийн ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 03 өдрийн 3/03 тоот тогтоолоор 2,525.4 сая төгрөгөөр анх баталж өмнө оны болон тайлант оны орлого давсан холбоотойгоор 2021 онд 1 удаа тодотгол хийн 2021 оны 08 дугаар сарын 05-ны 4/03 тоот тогтоолоор нийт 2,594.1 сая төгрөгөөр баталсан байна.

Төсвийн тодотголыг сумын ИТХ-аар 2021 оны 8 дугаар сарын 12-ны өдрийн 1/02 тоот тогтоолоор 2,594.1 сая төгрөгөөр 6 байгууллага, 2 сангийн төсвийг тодотгож баталжээ.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд 2,594.1 сая төгрөгийн төсөв баталснаас 1,523.4 сая төгрөгийг улсын төсвөөс, 714.2 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 31.5 сая төгрөгийг ЭМДС-аас, 149.5 сая төгрөгийг ОНХС-аас санхүүжих, 0.6 сая төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос, 150.4 сая төгрөгийг туслах үйл ажиллагаанаас, 24.5 сая төгрөгийг өмнөх оны үлдэгдлээс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Хүснэгт 3: Төлөвлөгөө, гүйцэтгэл

	сая. төгрөг	
	төлөвлөгөө	гүйцэтгэл
Улсын төсвөөс санхүүжих	1,523.4	1,521.0
Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,523.4	1,521.0
Орон нутгийн төсвөөс санхүүжих	863.7	864.1
Орон нутгийн төсвөөс	714.2	714.6
Орон нутгийн хөгжлийн сан	149.5	149.5
Нийгмийн даатгалын төсвөөс санхүүжих	31.5	31.0
Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	31.5	31.0
Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	175.5	175.1
Үндсэн үйл ажиллагааны орлогоос	0.6	0.2
Туслах үйл ажиллагааны орлогоос	150.4	174.9
Урьд оны үлдэгдлээс санхүүжих	24.5	
ЭХ ҮҮСВЭРИЙН НИЙТ ДҮН	2,594.1	2,591.2

Эх сурвалж: Чандмань сумын ТТЗ-ын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,521.0, орон нутгийн төсвөөс 714.6, ОНХС-ийн санхүүжилт 149.5, ЭМДС-аас санхүүжих 31.0, үндсэн үйл ажиллагааны орлогоос 0.2, туслах үйл ажиллагааны орлогоос 174.9 сая төгрөг нийт 2,591.2 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 2,551.1 мянган төгрөгийг зарцуулж 2.4 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,551.1 сая мянган төгрөг буюу 98.3 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 0.5, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 0.9, бараа хангамж, бараа материалын

зардал 0.2, нормативт зардал 2.1, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж 0.5, бараа үйлчилгээний бусад зардал 0.5, хөрөнгийн зардал 52.1, буюу нийт 55.7 сая төгрөгөөр батлагдсан төсвийг хэмнэж зарцуулсан, эргэж төлөгдөх зээлийг 14.3 сая төгрөгөөр илүү олгосонтой холбоотой байна.

Үндсэн үйл ажиллагааны орлогыг 0.6, туслах үйл ажиллагааны орлого 150.4 сая төгрөгөөр тус тус батлагдаж гүйцэтгэлээр үндсэн үйл ажиллагааны орлогыг 0.2, туслах үйл ажиллагааны орлогыг 174.9 сая төгрөгөөр нийт 175.1 сая төгрөгийн орлого бүрдүүлсэн. Нийт бүрдүүлсэн орлогын 134.7 сая төгрөгийг СХС, 37.8 сая төгрөгийг Чандмань хөгжүүлэх сангийн зээл, зээлийн хүүгийн орлого, 2.4 сая төгрөг нь малжуулах төслийн эргэн төлөлт, 0.2 сая төгрөг нь сумын ЗДТГ-ын өөрийн орлого бүрдүүлэн 1.8 төгрөгийг орон нутгийн төсөвт татан төвлөрүүлсэн байна.

Чандмань сумын ИТХ-ын 2021 оны орон нутгийн төсөв батлах тухай 2021 оны 8 дугаар сарын 12-ны өдрийн 1/02 дугаар тогтоолд Чандмань сумын Төвлөрүүлэн захирагчийн тайлант онд 59.4 сая төгрөгийн орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 61.2 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 103 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт 4. Сумын татварын орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл

/сая.төгрөг/

Орлогын ангилал	2021 оны		Зөрүү
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	
Татварын нийт орлогын дүн	59.4	61.2	1.8
Нийт орлого ба тусламжийн дүн	59.4	61.2	1.8
Татварын орлого	56.4	57.6	1.2
Орлогын албан татвар	29.4	13.4	(16.0)
Хувь хүний орлогын албан татвар	29.4	15.1	(14.3)
Үйл ажиллагааны орлого	2.0	6.9	4.9
Херенгийн албан татвар	19.5	29.9	10.4
Үл хөдлөх эд херенгийн албан татвар	-	6.4	6.4
Бууны албан татвар	3.2	4.3	1.1
Иргэдийн мөнгөн хадгаламжийн хүүгийн орлого	16.3	19.2	2.9
Бусад татвар, төлбөр, хураамж	4.6	5.1	0.5
Бусад нийтлэг төлбөр, хураамж	3.7	2.8	(0.9)
Улсын тэмдэгтийн хураамж	2.0	0.9	(1.1)
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны	1.0	1.3	0.3
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	0.7	0.6	(0.1)
Газрын төлбөр	0.2	0.4	0.2
Газрын төлбөр	0.2	0.4	0.2
Байгалийн нөөц ашигласны төлбөр	0.7	1.9	1.2
Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	0.2	0.3	0.1
Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр	0.5	1.6	1.1
Татварын бус орлого	3.0	3.6	0.6
Нийтлэг татварын бус орлого	3.0	3.6	0.6
Бусад орлого	-	2.3	2.3
Торгуулийн орлого	3.0	1.3	(1.7)

Эх сурвалж: Чандмань сумын ТТЗ-ын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийт орлого 59.4 сая төгрөг буюу 1.8 сая төгрөгөөр давуулсан үүнээс татварын орлого 1.2 сая төгрөгөөр, татварын бус орлого 0.6 сая төгрөгөөр тус тус давсан. Орлого давсан шалтгаан нь үйл ажиллагааны орлого 4.9, үл хөдлөх хөрөнгийн албан татвар 6.4, бууны албан татвар 1.1, иргэдийн мөнгөн хадгаламжийн хүүгийн орлого 2.9, түгээмэл тархацтай ашигт малтмалын 0.3, газрын төлбөр 0.2, ус рашаан ашигласны төлбөр 0.1, байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр 1.1 сая төгрөгөөр тус тус давсан байна. Хувь хүний орлогын албан татвар 14.3, улсын тэмдэгтийн хураамж 1.1, хог хаягдлын төлбөр 0.1, торгуулийн орлого 1.7 сая төгрөгөөр тасалжээ.

Татварын бус орлого 0.6 сая төгрөгөөр давж биелсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн тайлангаар Сангийн сайдын 2021 оны 87 тоот тушаалаар ЕБС-д 20.0, ЭМДС-аас Ковид-19 цар тахлын илүү цаг урамшуулал, эмийн зардалд 138.7, аймгийн Засаг даргын захирамжаар 1.0, Хөшөөт хөгжлийн сангаас 21.8, БСУГ-аас ЕБС болон СӨБ-ийн байгууллагад ажиллаж байгаа багш нарын тэтгэмж 49.6, БСУГ-аас ковид, бусад төслийн санхүүжилт 6.8, Статистикийн газраас судалгааны зардал 0.6, Засгийн газрын 211 тогтоолоор 9.9, бусад орлогоос 3.4 сая төгрөг нийт 251.8 сая төгрөгийн орлого бүрдүүлэн 249.3 сая төгрөгийг зарцуулж орон нутгийн төсөвт 2.4 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Чандмань сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны нэгтгэсэн санхүүгийн тайланд тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай дараах асуудлууд байна. Үүнд:

1. Сум хөгжүүлэх сангаас 2011-2020 онуудад олгосон 136 зээлдэгчийн 562.7 сая төгрөгийн зээл олгогдсоноос 3 иргэн нас барсан, 73 зээлдэгч зээл бүрэн төлж дууссан, 32 иргэний 167.0 сая төгрөгийн зээлийн төлөх хугацаа болоогүй, 22 иргэний 71.5 сая төгрөгийн мянган төгрөгийн зээлийн авлага нь хугацаа хэтэрч байгаа нь сангийн хөрөнгийн эргэцийг удаашруулж, хөрөнгийн үр өгөөжийг бууруулж байна.
2. “Эрдэс тайга” ХХК-тай 15 жилийн хугацаатай концессын гэрээ байгуулан сумын төсөвт байгууллагуудыг халаалт дулаанаар ханган ажиллаж тайлант онд өр төлбөр үүсээгүй тайлагнасан ч төсөвт байгууллагуудад батлагдсан төсвөөр гэрээ байгуулан зардлыг санхүүжүүлсэн байна.
3. Чандмань БИТ ОНӨААТҮГ-тай холбоотой 24.3 сая төгрөгийн насжилт өндөртэй, өр төлбөрийг барагдуулах боломжгүй асуудал байна.

3.8 Аудитын гол асуудал

Чандмань сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны нэгтгэсэн санхүүгийн тайланд УТХО-оор 1,334.9 сая төгрөгийн өртөг бүхий Нутгийн удирдлагын ордон, Халуун усны барилга шинээр баригдсан, данс бүртгэлд тусгасан, сумын Эрүүл мэндийн төв Ковид-19 цар тахлын үйлчилгээ үзүүлсний төлбөрт ЭМДС-аас авах 69.0 сая төгрөгийн авлага үүссэн асуудлууд нь үлэмж нөлөө үзүүлсэн байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу тус байгууллагын 2021 оны Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хяналаа.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 157 мэдээллээс 129 хугацаандаа оруулсан 28 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна. Аймгийн хэмжээнд сум хөгжүүлэх сангийн

Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг мэдээлэх тусгай цэсгүйгээс тайлант онд орсон орлогын гүйлгээг мэдээлээгүй, зарлагын гүйлгээ гаргаагүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 4.0 сая төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж өгөгдсөн бөгөөд 100 хувьтай хэрэгжүүлсэн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар Ковид-19 цар тахал, Шүлхий өвчинтэй холбоотой сумын төсөвт байгууллагуудаас гаргасан зардлын зарцуулалт, малжуулах төсөлд хамрагдах иргэдийн сонгон шалгаруулалт ил тод нээлттэй эсэх, олгосон санхүүжилтийн асуудлыг авч үзэх нь зүйтэй байна.

3.12 Харьяа байгууллагуудын аудитын дүнгийн талаар

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 6 төсвийн байгууллага, 2 тусгай сан, нийт 8 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 3 байгууллагыг аудитад хамруулан дүгнэлт гаргаж, 5 тайланг түүвэрт хамруулсан байна.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд “Зөрчилгүй”-1 (ЭМТөв), “Хязгаарлалттай” 2 (сумын 12 жилийн сургууль, сумын хүүхдийн цэцэрлэг) нийт 3 дүгнэлт гаргасан байна.

Чандмань сумын ТТЗ-ын нэгтгэлд хамрагдсан төсвийн шууд захирагчдын 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 520.9 сая төгрөгийн 25 алдаа зөрчил илэрч, 228.2 мянган төгрөгийн 13 алдааг залруулсан байна.

Залруулагдаагүй 292.7 сая төгрөгийн алдаа зөрчлөөс 15.6 сая төгрөгийн алдаа зөрчилд 5 төлбөрийн акт тогтоон, 0.9 сая төгрөгийн алдаа зөрчлийг арилгуулах 1 албан шаардлага өгч 276.2 сая төгрөгийн 6 алдаа зөрчилд зөвлөмж өгөгдсөн байна. Нийт алдаа зөрчил, шийдвэрлэлтийг хүснэгтээр харуулбал:

Дүгнэлт өгсөн байгууллагуудын зөрчлийн нэгтгэл Хүснэгт -5 /сая.төг/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Чандмань сумын сургууль	9	225.8	4	37.9	2	6.5			3	181.4
2	Чандмань сумын хүүхдийн цэцэрлэг	11	120.5	6	23.6	2	2.1	-		3	94.8
3	Чандмань сумын ЭМТ	5	174.6	3	166.7	1	7.0	1	0.9	-	-
Дүн		25	520.9	13	228.2	5	15.6	1	0.9	6	276.2

Эх сурвалж: Чандмань сумын ТТЗ-ын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

4. Нэгтгэсэн тайлангийн аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 466.1 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 132.9 сая төгрөгийн 13 алдааг залруулж, 1.0 сая төгрөгийн 1 алдаа зөрчилд төлбөрийн акт, 172.3 сая төгрөгийн 3 зөрчилд албан шаардлага, алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 160.0 сая төгрөгийн 10 зөвлөмж өглөө.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. ОНХС-ийн тайланд авлага, өглөг, бараа материал, тайлант үеийн үр дүн зөрүүтэй тайлагнасан 16.0 сая төгрөг,
2. СХС-ийн тайланд авлага, тайлант үеийн үр дүнд 9.6 сая төгрөг,
3. Сумын ЭМТөв, СӨБ нь тайлант хугацааны хуримтлагдсан зардал, акталсан хөрөнгийн хуримтлагдсан элэгдлийг э-тайлангийн цахим системд нэгтгэхдээ зөрүүтэй 39.6 сая төгрөг,
4. ТТЗ-ийн санхүүгийн тайлант сумын ЗДТГ-ын 2010 онд дахин үнэлгээ хийгдсэн хөрөнгийг акталж данс бүртгэлээс хасагдаж 4.2 сая төгрөгийн дахин үнэлгээний нэмэгдлийн бууралт, өмнөх оны үр дүн руу бичих бичилтийг орхигдуулсан,
5. ЗДТГ-ын ОНХС-аар бэлтгэсэн БҮТЭЗ орлого авч, үндсэн хөрөнгөд илүү бүртгэсэн хөрөнгийг хасаж, жолоочийн тооцоо бодолттой 63.5 сая төгрөгөөр тус тус залрууллаа.

Шийдвэрлэсэн нь: Шалгагдагч байгууллагын төсвийн захирагч, нягтлан бодогч нарт асуудлын бүртгэлээр танилцуулан 132.9 сая төгрөгийн залруулга хийсэн болно.

4.2 Төлбөрийн акт

1. Засгийн газрын 2020 оны 211 дүгээр тогтоолоор айл өрхийн цэвэр бохир усны хөнгөлөлтөд 9.9 сая төгрөгийг сумын ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн дансаар дамжуулан цэвэр ус түгээдэг хувь хүмүүст 8.9 сая төгрөгийн олгож 1.0 сая төгрөгийг зориулалтын бусаар зарцуулсан нь Засгийн газрын 211 дүгээр тогтоолын 5-д "Төрийн байгууллагын цахилгаан, дулаан, цэвэр бохир ус, хог хаягдлын үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлыг төлөвлөсөн хэмжээнээс бууруулахгүй, өөр зардалд шилжүүлэхгүйгээр цахилгаан, дулааны эрчим хүч, дулааны уур, ус хангамж, ариутгах татуурга, хог хаягдлын үйл ажиллагаа эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллагад шууд шилжүүлж байхыг төсвийн бүх шатны шууд захирагч нарт даалгасугай" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоов.

4.3 Албан шаардлага

4.3.1 **Илрүүлэлт:** СХС-ийн хөрөнгөөс 2011-2018 онуудад нийт 137 иргэнд 562.7 сая төгрөгийн зээл олгогдож 73 зээлдэгч зээлээ бүрэн төлж дууссан, гэрээний үүргээ биелүүлээгүй 22 зээлдэгчтэй холбоотой 72.0 сая төгрөгийн зээл, зээлийн хүүгийн хугацаа хэтэрсэн үлдэгдэлтэй, Малжуулах төслийн 2013- 2017 онд олгосон 46 иргэн холбоотой 54.2 сая төгрөг нийт 126.2 сая төгрөгийн авлага барагдуулаагүй сангийн дансанд төвлөрүүлээгүй зөрчил илэрлээ.

Энэ нь Зээлдэгчтэй байгуулсан гэрээний 7.2.4-д "Зээлийн эргэн төлөлт, хүүгийн орлогыг сангийн дансанд төвлөрүүлнэ", 8.2-д "Зээлдэгч зээлийн төлбөрийг сар бүрийн төлбөрийн хуваарийн дагуу төлнө", 9.2-д "Зээлдэгч гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй дараах тохиолдолд Зээлдүүлэгч гэрээг цуцалж, зээл, хүү нэмэгдүүлсэн хүүгийн төлбөрийг үл маргах журмаар төлүүлнэ. Үүнд: 9.2.1-д "Зээлийн гэрээний 3.2-т зааснаас өөр зориулалтаар ашигласан", 9.2.2-д "Зээлийн гэрээгээр тохиролцсон хуваарийн дагуу төлбөрөө бүрэн төлөлгүй 60 хоног хугацаа хэтэрсэн", 9.2.4-д "Гэрээгээр хүлээсэн үүргээ 2-оос дээш удаа зөрчсөн, эсвэл 15 дээш хоногоор хугацаа хэтрүүлсэн бол", ОНХС-ийн хөрөнгөөр малжуулсан малчинтай хийх зээлийн гэрээний 2-д "Малжуулах зээлийг зээлдэгч 2017 оны 8 дугаар сарын 14 ны өдрөөс эхлэн 3 жилийн хугацаанд хүү тооцохгүйгээр хуваарийн дагуу бүрэн төлж дуусгана" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөв.

4.3.2 **Илрүүлэлт:** Төрийн сангийн мэргэжилтэн нь ОНХС-аас зарлагын гүйлгээ гаргахдаа 2021 оны 7 дугаар сарын 2-ны өдөр "Ханagar Жаргалант" хоршоонд 1.5 сая төгрөгийн ажил гүйлгээг 15.0 сая төгрөгөөр, 2021 оны 10 дугаар сарын 14-ний 39 тоот төлбөрийн хүсэлтээр Отгонбаярын харилцах данс руу 1.0 сая төгрөгийн ажил гүйлгээг гаргахдаа 7.1 сая төгрөгөөр нийт 19.6 сая төгрөгийн ажил гүйлгээ буруу шивж зарлага гаргасан нь ажлын хариуцлага хангалтгүй байгаа нь ажлын байрны тодорхойлолтын 5 дугаар зорилтын хүрээнд 5.2-д "эрхэлсэн ажлын чиг үүргийн хэрэгжилтийг бүрэн хариуцаж, зөрчил дутагдал гарсан тохиолдолд хариуцлага хүлээх" гэсэн заалтыг мөрдөн ажиллаагүй зөрчил илэрлээ.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөв.

4.3.3 Илрүүлэлт: ОНХС-аас гамшгаас хамгаалах санд 29.6 сая төгрөг төлөвлөж зарцуулсан, Сангийн хөрөнгөөр гамшгийн үйл ажиллагааны шатахууны зардалд зарцуулсан дотоод хяналт сул жолоочийн тооцоо бодоогүй зэрэг зөрчил илэрлээ.

Энэ нь Гамшгаас хамгаалах тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1.-д “Төсвийн ерөнхийлөн захирагч нь жил бүрийн төсвийн багцдаа гамшгийн эрсдэлийг бууруулах арга хэмжээг төлөвлөж, зардлыг тусгана”, 51.4-д “Улсын хэмжээнд гамшгаас хамгаалах төвлөрсөн арга хэмжээний зардлыг улсын төсвөөс, аймаг, нийслэл, сум, дүүргийн гамшгаас хамгаалах арга хэмжээний зардлыг орон нутгийн төсвөөс санхүүжүүлж, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээд зардлаа өөрөө хариуцна”, 51.2-д “Гамшгаас хамгаалах, эрсдэлийг бууруулах арга хэмжээний зардалд аймаг, нийслэл, сум, дүүрэг, төрийн байгууллага тухайн жилийн төсвийнхөө 1.0 хувиас доошгүйг зарцуулахаар тооцон төсөвт тусгаж, хуулийн этгээд тухайн жилийн үйлдвэрлэл, үйлчилгээний зардлын 1.5 хувиас доошгүй хэмжээний хөрөнгийг төлөвлөж зарцуулна”, ОНХС-ийн үйл ажиллагааны журмын 11.2-д “ОНХС-ийн төсөв боловсруулах, батлах, зарцуулах, тайлагнах, бүртгэх, хяналт тавих, зохион байгуулахад хууль тогтоомж зөрчсөн бол тухайн байгууллага, албан тушаалтанд Төсвийн тухай хууль болон холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, Эд хариуцагчийн эрх үүргийн дүрмийн 17-д Өөрийн хариуцаж байгаа зүйлийн орлого, зарлагын болон үлдэгдлийн мэдээ тайланг тухай бүр зохих маягтаар хариуцсан нягтлан бодогчид өгч байна” гэсэн заалтуудыг мөрдөөгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөв.

4.4. Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

4.4.1 Авлагатай холбоотой асуудал

Илрүүлэлт: ЗДТГ-ын санхүүгийн тайланд 73.9 сая төгрөгийн авлага нь он дамжсан насжилт өндөртэй, эзэн холбогдогч нь тодорхой бус барагдуулаагүй зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, 20 дугаар зүйлийн 20.2.5-д “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалт хэрэгжээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Он дамжсан насжилт өндөртэй авлага барагдуулах талаар тодорхой ажил зохион байгуулж, авлагыг барагдуулах

4.4.2 Зээлдэгчтэй байгуулсан гэрээтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Сум хөгжүүлэх сангаас зээлдэгчтэй байгуулсан гэрээнд заасан СХС-аас олгох зээлийн гэрээнд заасны дагуу алданги тооцоогүй зөрчил илэрлээ.

Энэ нь сум хөгжүүлэх сангаас олгох барьцаат зээлийн гэрээний Сум хөгжүүлэх сангаас олгох зээл, барьцааны гэрээний 2.3-д “Зээл, хүүгийн эргэн төлөх хуваарь”-ийн дагуу төлөгдөөгүй зээлд хоног тутамд ногдох хүүгийн 0.5 хувьтай тэнцүү байна” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Сум хөгжүүлэх сангаас зээл олгосон зээлдэгч нартай байгуулсан гэрээг шинэчлэн гэрээнд заасны дагуу алданги тооцон, СХС-ийн программд мэдээллийг үнэн зөв оруулж хэвших

4.4.3 Тооллого хийх, дотоод хяналттай холбоотой асуудал

Илрүүлэлт: ЗДТГазар нь бараа материалын зарлага гаргахдаа холбогдох албан тушаалтнаар батлуулсны дараа материалаа олгодоггүй, тооллого хийж үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, дотоод хяналт хэрэгжүүлээгүй зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-д "Төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах" 20 дугаар зүйлийн 20.2.6-д "Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д "анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолын 1.3-д "аж ахуйн нэгж, байгууллага нь энэхүү нийтлэг журамд нийцүүлэн, өөрийн үйл ажиллагааны онцлогт тохирсон "дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам"-тай байна", 1.5-д "... Журмын 1.4-т зааснаас бусад тохиолдолд "дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам" тухайн байгууллага, аж ахуйн нэгж өөрөө баталж мөрдөнө" гэсэн заалтуудыг мөрдөөгүйтэй холбоотой байна.

Өгсөн зөвлөмж: Дотоод хяналт хэрэгжүүлэн, анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлж тооллого тооцоог тухай бүр хийж хэвших,

4.4.4 Ерөнхий чиглэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Засгийн газрын 43 дугаар тогтоолын дагуу батлагдсан төсөвт зардлын 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргаагүй, төсөвт төвлөрүүлээгүй 36.2 сая төгрөгийг үйл ажиллагааны зардалд зарцуулсан зөрчил илэрлээ.

Энэ нь Засгийн газрын 2021 оны 2 дугаар сарын 17-ны 43 дугаар тогтоолын 1.1-д "үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах" гэж заасан заалтыг хэрэгжүүлээгүйтэй холбоотой байна.

Зөвлөмж: Холбогдох тогтоол журмын заалтыг мөрдөн ажиллаж тэвчиж болох зардлыг хэмнэн төсвийн хэмнэлт гарган ажиллах

4.4.5 Шилэн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Соёлын төв нь Шилэн дансны хуульд заасны дагуу цалингаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй орлогын 30.4 сая төгрөгийн санхүүжилтийн ажил гүйлгээг мэдээлээгүй байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр;" Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан журмыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Хууль, журамд заасны дагуу Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг ханган холбогдох мэдээллийг үнэн мэдээлж хэвших

4.4.6 Төсвийн гүйцэтгэл, төсвийн төлөвлөлттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Сумын төсөвт байгууллагын дүнгээр тогтмол зардлыг 200.3 сая төгрөгөөр төлөвлөж, төсвийн гүйцэтгэлийн тайланд тусгасан 198.7 сая төгрөгөөр, Төрийн сангийн зарлагын хуулгаар 194.2 сая төгрөгийн зардал гаргаж 6.1 сая төгрөгийг бусад бараа үйлчилгээний зардал гүйлгэн зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.7-д "энэ хуулийн 22.2-т заасан төсвийн ангиллын төрөл бүрээр дэлгэрэнгүй ангилал тогтоох, түүнийг төсвийн төлөвлөлт, тайлагналт, гүйцэтгэлд ашиглах журмыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тогтооно", 16.5.7-д "байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах", Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар"-ыг мөрдөн ажиллах заалтуудыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Эдийн засгийн ангиллын дагуу төсөвт журмын дагуу зохицуулалт хийж зардлыг санхүүжүүлэн, Төсвийн гүйцэтгэлийн тайланг үнэн зөв илэрхийлж тайлагнах

4.4.7 Орон тоотой холбоотой асуудал

Илрүүлэлт: Соёлын төв нь тайлант онд батлагдаагүй орон тоонд ажил хавсран ажилласны нэмэгдэлд 1.4 сая төгрөгийг олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.9-д “дээд шатны төсвийн захирагчийн зөвшөөрснөөр үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, чиг үүргийн давхардлыг арилгах, ажлын ачааллыг нягтруулах, бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтцийг батлагдсан орон тооны хязгаар, төсвийн хүрээнд шинэчлэн тогтоох” гэсэн заалттай нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Батлагдаагүй орон тоонд нэмэгдэл цалин олгохгүй байх

4.4.8 НДШимтгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: ЗДТГ-ын багийн сахиулд улирал бүр урамшуулалт цалин олгохдоо нийгмийн даатгалын шимтгэл тооцож 0.7 сая төгрөгийг суутган аваагүй зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-д “Төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах”, 20 дугаар зүйлийн 20.2.5. “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, Нийгмийн даатгалын багц хуулийн 32 дугаар зүйлийн “Нийгмийн даатгалын шимтгэл ногдуулах хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлого” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Нийгмийн даатгалын шимтгэлийг суутган авч, шимтгэлийн тайланг сар бүр гаргаж хэвших

4.4.9 Анхан шатны баримт, Засгийн газрын тогтоолтой холбоотой асуудал

Илрүүлэлт: Тайланд онд ЗГ-ын тогтоолоор ундны усны хөнгөлөлтөд хамрагдсан айл өрхөд зарцуулсан ундны усны санхүүжилтийг худгийн ус түгээгчдэд олгохдоо нотлох анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлээгүй 8.8 сая төгрөгийг олгосон илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-д “Төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-д “ Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 13.7-д “ Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалттай нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Гүйцэтгэсэн ажлын тайлан, олгосон бодит усны хэрэглээнд зарцуулсан анхан шатны баримтыг бүрдүүлэх

4.4.10 Төсвийн төлөвлөлт, зарцуулалттай холбоотой асуудал

Илрүүлэлт: ИТХ-ын үйл ажиллагааны зардалд төсвийн тодотголоор 2.6 сая төгрөгөөр тодотгон үйл ажиллагааны зардалд зарцуулсан зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-д “Төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах”, 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэсэн заалтыг зөрчсөн.

Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн холбогдох заалтыг мөрдөн ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 06 дүгээр сарын 03-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5

Чандмань сумын ТТЗ-ын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

Хүснэгт – 6

/сая. төгрөгөөр/

д/д	Байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Чандмань ТТЗ	8	79.1	4	43.8	1	1.0	1	19.6	2	14.7
2	Чандмань ЗДТГ	6	174.3	2	63.5					4	110.9
3	Чандмань ИТХ	1	2.6							1	2.6
4	Чандмань Соёлын төв	2	31.8							2	31.8
5	Чандмань ОНХС	5	96.7	4	16.0			1	80.7		
6	Чандмань СХС	5	81.6	3	9.6			1	72.0	1	
Дүн		27	466.1	13	132.9	1	1.0	3	172.3	10	160.0

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

Х.БОЛДБААТАР

АУДИТЫН МЕНЕЖЕР:

А.ЦЭЦЭГСҮРЭН

ТАЙЛАНГ БИЧСЭН:

АХЛАХ АУДИТОР:

Д.НАРАНТУУЛ

